Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 2/46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хуулиар хүлээлгэсэн нийтлэг бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлэхийн төлөө бүх хүчин чадал, ур чадвар, хуримтлуулсан туршлагаа дайчлан чин шударгаар ажиллан, тэргүүний эвсэг, шилдэг хамт олон бүрдүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Иргэний нийгэм, төрийн байгууллагын түншлэл, ил тод байдал, хариуцлагын тогтолцоо нь хуулиа дээдэлсэн, төрийн үйлчилгээ нь нээлттэй, шуурхай хүнд суртал, чирэгдэлгүй, ёс зүйтэй, ажил хэрэгч, иргэдийн санал хүсэлтийг хүндэтгэсэн байх

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2021 онд 2019, 2020 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж 2021 оны 03 сарын 19-ний өдөр 18-03/07 дугаартай данс бүртгэлээс завсардсан өвс, тэжээлийн үнийг төлүүлэх тухай 938.9 мянган төгрөгний төлбөрийн акт тогтоосон байна.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,600.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 36.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 38.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 134.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 231.5 сая төгрөг болж, 97.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	107.2	231.5	124.3	100.0
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Арилжааны банкинд байгаа мөнгө	26.9		-26.9	
Дүн	134.2	231.5	97.3	100.0

Эх сурвалж: Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 231.5 сая төгрөг байгаагаас 110.2 сая төгрөг нь сумын орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 18.0 сая төгрөг нь ЗДТГ-ын, 3.9 сая төгрөг нь БОХСангийн, 59.8 сая төгрөг нь ОНХСангийн, 39.6 сая төгрөг нь СХСангийн дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Тус сумын ТШЗ-ийн тайлангаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 250.4 сая, эцсийн үлдэгдэл 243.5 сая төгрөг болж, 6.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	6.4	0.5	-5.9
Төлбөртэй үйлчилгээний авлага		33.4	33.4
Татаас, санхүүжилтийн авлага			-
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	13.0	8.2	-4.8
Зээлийн авлага	231.0	201.3	-29.7
Дүн	250.4	243.4	6.9

Эх сурвалж: Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна. Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл 201.3 сая төгрөг байгаа нь нийт авлагын 83.1 хувийг эзлэж, тайлант онд авлагын эргэн төлөлтөөс олгосон зээлийн хэмжээ бага учир авлага хасагдсан байна.

Төсөвт байгууллагуудаас сумын Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 33.4 сая төгрөгийн санхүүжилтийн авлага шинээр нэмэгдсэн нь Ковид-19 цар тахлын улаан бүсэд ажилласан ажилчдын урамшуулалт цалин байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн баталгаажуулах аудитаар 2021 онд шууд гэрээгээр хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний бүртгэл тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Сумын Засаг даргын орлогчийн “Толбо магнай” ХХК-тай 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан БӨАТСЗДТГ/202105014 тоот “Толбо сумын өвс тэжээлийн нөөцөд боодолтой өвс нийлүүлэх” 20,0 сая төгрөгийн дүнтэй гэрээний дагуу 2021 оны 12 дугаар сарын 21,23-ны өдөр тус компани дансанд нийт 16.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээний хугацаа нь 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр дууссан бөгөөд ажлыг хүлээж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

2. Сумын Засаг даргын орлогчийн “Грийн жаспер” ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 18 өдөр байгуулсан БӨАТСЗДТГ/202105013 тоот “Арьс ширний цех барих, тоног төхөөрөмж нийлүүлэх” 20.0 сая төгрөгийн дүнтэй гэрээний дагуу 2021 оны 10 дугаар сарын 25, 12 дугаар сарын 13-ны өдөр тус компани дансанд нийт 16.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээний хугацаа нь 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр дууссан бөгөөд ажлыг хүлээж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

3. Мөн гэрээ байгуулаагүй, зөвхөн нэхэмжлэлээр “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-д “Толбо сумын төвийн 2.31 км авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам, сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын үнэ”-д 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр 10.0 сая төгрөг шилжүүлсэн боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар дээрх зөрчлүүдийг шалгах цаг хугацааны боломжгүй байгаа учраас Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр

дүнд 2022 оны 5 дугаар сард хийх төлөвлөгөөт гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан шалгах шаардлагатай гэж үзлээ.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 279.8 сая, эцсийн үлдэгдэл 286.1 сая төгрөг болж, 6.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	9.7	16.2	6.5
Хангамжийн материал	222.2	255.3	33,1
Мал амьтад	47.9	14.6	-33.2
Дүн	279.8	286.1	6.3

Эх сурвалж: Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 286.1 сая төгрөг болж 6.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд сумын төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 344.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 34.6 сая төгрөгийн материал үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгаж, үйл ажиллагаандаа 343.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2.7 сая төгрөгийг акталсан байна. Хүүхдийн цэцэрлэг бараа материалын дансанд урьд жилүүдэд хоолны зардлын төсвөөс худалдан авч хүнсний материалд бүртгэж ирсэн 1.9 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалаас хасаж үндсэн хөрөнгөд шилжүүлсэн байна

Бараа материалын нийт үлдэгдлийн 30.7 сая төгрөг нь ЗДТГ-ын, 2.3 сая төгрөг нь ИТХ-ын 153.4 сая төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулийн, 66.8 сая төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн, 30.7 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 1.3 сая төгрөг нь Соёлын төвийн, 0.8 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудын үлдэгдэл байна. Сумын ЭМТ-ийн материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор худалдан авсан, үнэгүй хүлээн авсантай холбоотой материалын үлдэгдэл нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын төсөвт байгууллагуудаас бараа материалтай холбоотой дарах зөрчил дутагдал илэрсэн байна. Үүнд:

1. Хүүхдийн цэцэрлэг хүнсний материалаас цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны А/16 тоот тушаалаар 238.5 мянган төгрөгийн, А/18 тоот тушаалаар 2469.3 мянган төгрөгийн нийт 2707.8 мянган төгрөгийн чанар байдлаа алдсан хүнсний материалыг акталж данснаас хассан байна. Ингэхдээ мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, дүгнэлт гаргуулаагүй, устгалтын акт үйлдэж баримтжуулаагүй байна.

2. Мөн Хүүхдийн цэцэрлэг санхүүгийн тайлангаар бараа материалын дансанд 66.8 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг зохих ёсоор хийж үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс аж ахуйн материал дансны үлдэгдэл 15.5 сая төгрөгөөр дутуу, бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 0.1 сая

төгрөгөөр илүү байгаа бөгөөд тооллогын дүнг санхүүгийн тайлангийн дахь хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулах боломжгүй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4259.4 сая, эцсийн үлдэгдэл 4284.6 сая төгрөг болж, 25.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4225.4	4250.1	24.7
Биет бус хөрөнгө	34.0	34.4	0.4
Дүн	4259.4	4284.6	25.1

Эх сурвалж: Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 15.4 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 85.2 сая, бусад 160.6 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, 25.0 сая төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын төсөвт байгууллагуудаас үндсэн хөрөнгөтэй холбоотой дарах зөрчил дутагдал илэрсэн байна. Үүнд:

Хүүхдийн цэцэрлэг санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд 580.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг зохих ёсоор хийж үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс тавилга эд хогшил дансны үлдэгдэл 3.4 сая төгрөгөөр, ном 2.7 сая төгрөгөөр дутуу байгаа бөгөөд тооллогын дүнг санхүүгийн тайлангийн дахь хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулах боломжгүй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4.6 сая, эцсийн үлдэгдэл 6.7 сая төгрөг болж 2.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	1.5		-1.5	0.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг				0.0
Байгууллагад төлөх өглөг	3.1	6.7	3.6	100.0
Хувь хүмүүст төлөх өглөг				0.0
Нийт дүн	4.6	6.7	2.1	100.0

Эх сурвалж: Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдэл 6.7 сая төгрөг нь байгууллагад төлөх өглөг байна. Ажилчидтай холбоотой өглөгийг бүрэн барагдуулсан байна.

Өр төлбөр дансанд тайлант оны өглөг нэмэгдсэн шалтгаан нь оны эцэст сумын ЭМТ-ийн вакцинжуулалттай холбоотой тээвэр шатахууны 4.1 сая төгрөгийн, ЕБС-ийн 2.6 сая төгрөгийн өглөг байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын төсөвт байгууллагуудын тайлангаар өглөгтэй холбоотой зөрчил дутагдал гараагүй байна

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4919.1 сая, эцсийн үлдэгдэл 5039.0 сая төгрөг болж, 119.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2288.4	2288.4	0	45.4
Хуримтлагдсан үр дүн	183.1	302.9	119.9	6.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2447.6	2447.6	0	48.6
Дүн	4919.1	5039.0	119.9	100.0

Эх сурвалж: Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5039.0 сая төгрөг болж 119.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өөрчлөлт ороогүй байна. Хуримтлагдсан үр дүн 302.9 сая төгрөг болж 119.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5.10. Орлогын данс

Толбо сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 143.4 сая төгрөгийн орлого оруулж, тусламж санхүүжилтийн орлогоор тусгай зориулалтын шилжүүлгээс 2384.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 724.3 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 96.9 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 159.3 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 57.5 сая төгрөг оруулан, үнэ төлбөргүйгээр 299.4 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч, нийтдээ 3,842.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 3842.0 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 348.2 сая төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсвийн урсгал, нэмэлт санхүүжилт, орон нутгийн төсөв, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал, ЭМД-ын сангийн санхүүжилт байна.

3.5.11 Зардлын данс

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 3600.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 230.8 сая төгрөгөөр буюу 7.5 хувиар өссөн байна. Нийт зардлын 97.9 хувь нь бараа үйлчилгээний зардал, 2.1 хувь нь урсгал шилжүүлэг байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, НДШ, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, бараа үйлчилгээний бусад зардалууд 0.8-81.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Толбо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 3290.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3145.4 сая төгрөгийг урсгал зардалд, 144.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2384.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 707.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 144.8 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 32.2 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 20.7 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Толбо сум нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 3290.3 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 2376.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 707.2 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 31.7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 144.8 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 29.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 29.7 сая төгрөгийн орлого нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Нийт санхүүжилтээс 7.9 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн ба орон нутгийн төсвөөс 0,3 сая төгрөгийн, ЭМДС-гаас 0.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлого 9.0 сая төгрөгөөр давж биелэгдсэн үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3220.4 сая төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилтэй холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Толбо сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 127.6 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 41 дүгээр тодотголоор 127.6 сая төгрөгөөр хэвээр нь баталсан байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 23 дугаар хуралдааны тогтоолоор 2021 орлогын төлөвлөгөөг 127.6 сая төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 175.5 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 48.0 сая төгрөгөөр буюу 37.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Өсөлт/+/, бууралт /-/ хувь	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	120.6	165.4	44.9	94,2
II.Татварын бус орлого	7.0	10.1	3.1	5,8
Нийт дүн	127.6	175.5	48.0	100.0

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос үйл ажиллагааны орлогын албан татвар 4.6 сая төгрөгөөр, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 4.6 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.3 сая

төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 1.8 сая төгрөгөөр, газрын төлбөр 2.2 сая төгрөгөөр төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний давж биелэгдэхэд хүү торгуулийн орлого 3.3 сая төгрөгөөр, ашигт малтмалын нөөцийн төлбөрөөс 23.9 сая төгрөгийн, бусад нэр заагдаагүй орлогоос 20.8 сая төгрөгийн орлого оруулсан нь орон нутгийн орлого давж биелэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 55.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 175.5 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 110.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №8 Төсвийн байгууллагуудын 2021 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	62.4	61.9	0,5
2	Сумын ЗДТГ	344.2	326.5	17.8
3	Ерөнхий боловсролын сургууль	1,768.9	1,761.4	7.5
4	Хүүхдийн цэцэрлэг	332.6	332.0	0.5
5	Соёлын төв	88.5	88.5	-
6	Эрүүл мэндийн төв	528.1	527.6	0.5
7	ОНХСан	144.7	121.2	23.5
8	СХС	16.8	1.3	15.5
9	БОХС	3.9		3.9
	Нийт дүн	3,290.1	3,220.4	69.7

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 128.1 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 31.1 сая төгрөгийн, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 0,05 сая төгрөгийн нийт 159.3 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 56.2 сая, гэрэл цахилгаанд 0.3 сая, хангамжийн материалын зардалд 15.8 сая, норматив зардалд 15.7 сая томилолтын зардалд 1.9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 25.3 сая, тэтгэмж, шагнал урамшуулалд 37.6 сая төгрөгийн, нийтдээ 152.8 сая төгрөгийг зарцуулж, 6.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Толбо сумын Засаг дарга нь 2021 онд нийт 3364.4 сая төгрөгийн 79 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 63 мэдээллийг хугацаандаа байршуулж, ТЕЗ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн улирал, сар бүр оруулах мэдээлэллийн 3.364,4 сая төгрөгийн 12 мэдээллийг хугацаандаа байршуулаагүй, 4 мэдээллийг хугацаа хоцроосон.

Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 29.7 сая төгрөгийн орлого болон 207.7 сая төгрөгийн зээлийн авлагын талаарх мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй зөрчил албан шаардлага өгсөн болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус ТТЗ-ийн багцад хамаарах 6 байгууллагыг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Хүүхдийн цэцэрлэг 2021 онд нийт 393.3 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 375.4 сая төгрөгийн 115 мэдээллийг хугацаандаа байршуулж, 17.9 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага өгөгдөөгүй, шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгөгдсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 2/211 тоот албан бичгээр ирүүлсэн.

Хүснэгт: №7 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1	0	1	0			50
Нийт	1	0	1	0			50

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт, Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Сумын ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой залруулга гараагүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

1. Толбо сумын Засаг даргын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн улирал, сар бүр оруулах мэдээлэллийн 3.364,4 сая төгрөгийн 12 мэдээллийг хугацаандаа байршуулаагүй, 4 мэдээллийг хугацаа хоцроосон, шилэн данстай холбоотой өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-д “өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 310.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс ЗДТГ-ын санхүүгийн тайлангаар 18.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, шилэн данстай холбоотой 17.9 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Ерөнхий боловсролын сургуульд 1.4 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэгт 24.2 сая төгрөгийн, Сум хөгжүүлэх санд 237.4 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн санд 11.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

Хүснэгт 9: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	2	35.9			1	18.0			1	17.9
2	Ерөнхий боловсролын сургууль	1	1.4					1	1.4		
3	Хүүхдийн цэцэрлэг	2	24.2					2	24.2		
4	Сумын СХСан	1	237.4					1	237.4		
5	ЭЭСан	1	11.6					1	11.6		
Нийт дүн		7	310.5			1	18.0	5	274.6	1	17.9

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

1. Албан тушаалын чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт:

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2 дугаар гарын үсгийг Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч зурж, тайлан баланс гаргаж ирүүлсэн байна.

Энэ нь Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Санхүүгийн албаны даргын ажлын байрны тодорхойлолтын албан тушаалын 2 дугаар зорилтын 12, 3 дугаар зорилтын 1-д заасныг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах зөрчлийг арилгаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Толбо сумын ТТЗСНТайлан	2						1	3,364.4	1	